



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/601

Хэрлэн сум

Сум, орон нутгийн гэр бүлд хүргэх
явуулын үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын 2025 оны 05 дугаар хуралдааны 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Ирээдүйн эзэд” хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.6.1 дэх хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд “Сум, орон нутгийн гэр бүлд явуулын үйлчилгээ үзүүлэх” зардалд 8,000,000 (найман сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Үйлчилгээний хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангаж, үр дүнг танилцуулж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Х.Уртнасан)-д үүрэг болгосугай.

3. Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Ирээдүйн эзэд” хөтөлбөрийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Н.Үнэнбат)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (А.Жаргалсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ



